



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/528

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.7, 15.9, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль, эрх зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны ээлжит XVIII хуралдааны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулийн этгээдийн хүсэлт, ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдүүдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Д.Мөнхжаргал), аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.


5.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСАЛТ

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 06-ний өдрийн
№/598 дугаар захирамжийн хавсралт



№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч			Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Хуулийн этгээдийн нэр	Байршил			
1	Дэвжид хантайн ХХК	Жаргалант сум 5-р баг Баянхангай" хүнсний дэлгүүр	98654878	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх	
2	Миний дэлгүүр ХХК	Мөрөн сум 8-р баг Миний дэлгүүр-317" салбар супермаркет	88006181	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	
3	Хөх гол август" ХХК	Мөрөн сум 4-р баг 13-01 тоот Скай" хүнсний дэлгүүр	99312727	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	
4	Сомо сарьдаг ХХК	Ханх сум 3-р баг Сомо сарьдаг" ХХК	88305704	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	
5	Чингүн солонго ХХК	Мөрөн сум 9-23-10 тоот Солонго" хүнсний дэлгүүр	99132773	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	
6	Арвайн нөөлөг ХХК	Тариалан сум Бадрах сант 1-44 тоот "Арвай" супермаркет	89117727	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	
7	Ашид Агар Ариг ХХК	Мөрөн сум 12-9-27 тоот Ашид" хүнсний дэлгүүр	88714427	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	
8	Бүрэн дүүрэг булаг ХХК	Мөрөн сум 4-22-22 тоот "Бүрэнбулаг" хүнсний дэлгүүр	88507989	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах	

9	Идэрмөрөн баялаг хүнс ХХК	Мөрөн сум 13-55-1 тоот Идэр мөрөн" хүнсний дэлгүүр	98938909	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
10	Өсөн нэмэх арвин ХХК	Мөрөн сум 7-19-20 тоот Арвин-2" хүнсний дэлгүүр	88704057	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
11	Хайс жарга ХХК	Мөрөн сум 14-6-11 тоот "Жаргалан" хүнсний дэлгүүр	99332440	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
12	Арвин нар хурах ХХК	Мөрөн сум 9-39-1 тоот Оргил" хүнсний дэлгүүр	86880229	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
13	Бургаст түрүү" хоршоо	Цагаан-Уул сум, 6-р баг Оргил" мини маркет	99173102	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах